



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 1/607

Улаанбаатар хот

Ажил хүлээн авах комисс
томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Иргэний хуулийн 351 дүгээр зүйлийн 351.1.2 дахь заалт Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Агаарын хөлгийн шатахуун тээвэрлэх автомашин 1 ширхэг нийлүүлэх ИНЕГ/УТ/ТББ/Б-03/18 дугаар гэрээт ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга:

А.Баасандагва

Нисэх буудлуудын удирдах газрын
үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн
дарга

Гишүүд :

Ц.Төрмөнх

Газрын тусгай үйлчилгээний албаны
ерөнхий инженер

Д.Батцоож

Газрын тусгай үйлчилгээний албаны
засварын инженер

Ч.Болдбаатар


Худалдан авах ажиллагааны тасгийн
ахлах инженер

С.Тамир

Үйлдвэрлэлийн нягтлан бодох
бүртгэлийн албаны нягтлан бодогч

2. Дээрх ажлыг техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын шаардлагын дагуу шалгаж хүлээн авах, гэрээний хэрэгжилтийг дүгнэн комиссын акт, холбогдох бусад материалын хамт Худалдан авах ажиллагааны тасагт хүргүүлэхийг ажил хүлээж авах комисс /А.Баасандагва/-г үүрэг болгосугай.

ДАРГА



Л.БЯМБАСҮРЭН

C:\My documents\TUSHAAL\2018 on\komiss tomiloh.docx

03 3000